


ИРГЭДИЙН



2023 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСВИЙН
МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАВ





Швейцарын хөгжлийн агентлаг болон Нийгмийн эгэх хариуцлагын дэлхийн түншлэлийн санхүүжилтээр Дэлхийн банкны хэрэгжүүлж буй "Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь" буюу MASAM II төслийн хүрээнд тус аймгийн "Иргэдийн төсөө" эмхэтгэлийг бүтээв.

МЭНДЧИЛГЭЭ



Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь төр, иргэдийн хооронд бат бөх түншлэл бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

Аймгийн 2023 оны орон нутгийн төсөв нь цар тахлын дараах улс орны эдийн засгийг эрчимтэй сэргээх зорилтыг хангахад чиглэсэн шинэ сэргэлт, төрийн албаны болон төсвийн шинэчлэлийг дэмжих бодлого, чиглэлийг үндэслэл болгон төсвийн нэгдмэл, тогтвортой, тэнцвэрт, бие даасан байдлыг бататгах, төсвийн төвлөрлийг сааруулах, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

Татвар төлөгч иргэн таны болон аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн үр шимээс бүрдэж байгаа төсвийг чухам юунд зарцуулж буй, ямар үр дүнд хүрэх талаар нээлттэй мэдээлснээр иргэд төсөв боловсруулах үйл явц дахь өөрсдийн оролцоог нэмэгдүүлэх, цаашлаад төлсөн татварынхаа төгрөг нэг бүрийг хэрхэн зарцуулж

буйд хяналт тавих боломж бүрдэх юм.

Дорноговь аймгийн орон нутгийн 2023 оны төсвийн мэдээлэл “Иргэдийн төсөв- 2023” эмхэтгэлийг хэвлүүлэн иргэд та бүхэндээ толилуулж байна. Уг эмхэтгэлд орон нутгийн төсөв, төсвийн бодлого, эх үүсвэр, аймаг, сумын татварын болон татварын бус орлого, зарлагыг ангилал бүрээр оруулсан билээ.


Төсөв боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог хангах, төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулан энэхүү эмхэтгэлийг санаачлан боловсруулж буй Дэлхийн банкны “Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” буюу MASAM II төслийн баг, хамт олонд талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

ОЧИРПҮРЭВИЙН БАТЖАРГАЛ
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА



АГУУЛГА:





ДОРНОГОВЬ АЙМАГ



ДОРНОГОВЬ АЙМАГ




Дорноговь аймаг нь Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгууд болон БНХАУ-тай хиллэдэг. Аймгийн төв Сайншанд хот Улаанбаатар хотоос 463 километр зайтай, төмөр замын дагуу оршдог. Монгол улсын хамгийн урт төмөр зам, авто замын сүлжээ тус аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрдөг. 2022 оны жилийн эцсийн байдлаар хүн амын тоо 71800, малын тоо толгой 2,909,700. Сайншанд хот нь 1931 онд тэр үеийн Их Дулаан уулын хошууны төв байсан “Далай сайн шанд” хэмээх газар байгуулагдсан түүхтэй.

НИЙТ ХҮН АМЫН ТОО


109.5 мянган км²
газар нутагтай



ДНБ (тэрбум төгрөг)



Нийт малын тоо 2,706.8 мянган толгой



ТӨСӨВ ГЭЖ ЮУ ВЭ?

Төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж зарцуулах хөрөнгө




















ТӨСВИЙН БҮТЭЦ



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТЭНЦЭЛ



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ТАТВАРЫН ОРЛОГО

2022 оныг хүртэл:	▶ 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөж буй
	 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь ШИНЭ
 Нийслэл хотын албан татвар	 Нийслэл хотын албан татвар
 Газрын төлбөрийн орлогын 60%	
 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	
 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
 Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	 Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр
 Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар	
 Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар	 Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар
 Улсын тэмдэгтийн хураамж	 Улсын тэмдэгтийн хураамж
 Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 20 хувь	 Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 20 хувь



Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Дорноговь аймгийн хилийн Замын-Үүд боомтыг олон улсын жишигт нийцүүлэн өргөтгөх ажил хийгдлээ. Энэ хүрээнд “Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц” төслийн нэгжийн гүйцэтгэлээр хилийн хамгийн том боомт болох Замын-Үүд боомт олон улсын жишигт нийцсэн шинэ зорчигч тээврийн хэсгээ 2023 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр нээв. Мөн хил гаалийн шалган нэвтрүүлэх хэсгүүд сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр шинэчлэгдэж, улам нарийвчилсан арга технологиуд нэвтрүүлэв.




ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН:

Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилсан хөрөнгө

ИРГЭДИЙН ОРОЛЦОО



ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР



МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ОРЛОГО

ШИНЭ

Нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээ нь 0-2000 төгрөг байна.

Албан татварын хэмжээг даархи хязгаарт багтаан сум, дүүргийн ИТХ малын төрөл тус бүрээр тогтооно.


- Дараах зүйлд зарцуулна. Үүнд:
- ✓ Балнээрийн менежментийг сайжруулах;
 - ✓ Балнээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;
 - ✓ Малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
 - ✓ Малын чанарыг сайжруулах;
 - ✓ Гэмт халдлага, гамшгаас хамгаалах;
 - ✓ Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;
 - ✓ Малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх;
 - ✓ Байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх;
 - ✓ Малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.



АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСӨВ

АЙМГИЙН НЭГДСЭН ТӨСӨВ (сая төгрөг)

ОРЛОГО



Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”, Боомтын сэргэлтийн хүрээнд “Хилийн Ханги” боомт нь халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн нэг ч өдөр зогсолтгүйгээр, 41528 жолооч улсын хилээр нэвтэрч, нүүрс 3,001,746.85 тн, жонш 6,637.25 тн, төмрийн хүдэр 46,752.2 тн нийт 692,8 сая ам.долларын статистик дүн бүхий уул уурхайн ашигт малтмалын бүтээгдэхүүн экспортлож, 4,6 тэрбум төгрөгийн хураамжийн орлого улсын төсөвт төвлөрүүлсэн түүхэн амжилтыг үзүүллээ.



ЗАРЛАГА



**НИЙТ
ЗАРЛАГА
126,832.2**

Улсын төсөвт
төвлөрүүлэх орлого
₮ 8,783.7

Орон нутгийн төсвийн
урсгал зардал

₮ 44,343.4

Хөрөнгийн зардал

₮ 42,362.5

ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН
САН

₮ 31,342.6

₮ 13,146.6
Цалин хөлс,
адилтгах зардал

₮ 29,717.1
Бараа үйлчилгээний
зардал

₮ 1,479.7
Татаас, шилжүүлэг

₮
Бусад зардал

₮ 11,946.6
Барилга,
байгууламж

₮ 4,280.5
Их засвар


₮ 2,992.8
Тоног, төхөөрөмж

₮ 23,142.6
Бусад хөрөнгө

₮ 21,427.4
Аймгийн
ОНХС

₮ 9,915.2
Сумдын
ОНХС





ЗАРЛАГА

▲ бууралт /өсөлт, бууралт /өмнөх ондос/

**НИЙТ
ЗАРЛАГА**
96,935.4
-5.0% ▼



19,518.4 **-1.6% ▼**

Нутгийн удирдлага



1,712.8 **26.8% ▲**

Байгаль орчин

314.5 **0.0% ▼**

Боловсрол, спорт



0.0% ▼

Соёл

0.0% ▼

Эрүүл мэнд



146.4 **0.0% ▼**

Нийгмийн хамгаалал

0.0% ▼

Хот тохижилт, нийтийн аж ахуйн үйлчилгээ



1,384.2 **0.9% ▲**

Зам, тээвэр

500.0 **11.1% ▲**

Хөтөлбөр, төсөл, арга хэмжээ



39,814.5 **-27.9% ▼**

Хөрөнгө оруулалт

21,427.4 **35.9% ▲**

ОНХС



1,735.7 **-17.6% ▼**

Эргэн төлөгдөх зээл

Бусад

0.0% ▼



**АЙМГИЙН ТӨСВИЙН
НИЙТ ЗАРЛАГА**

86,553.9 **-10.1% ▼**

1,597.8 **29.4% ▲**


Сумдад олгох санхүүгийн дэмжлэг



8,783.7 **90.2% ▲**

Улсад төвлөрүүлэх орлого







2023-2024 ОНЫГ “НЭЭЛТТЭЙ ДОРНОГОВЬ” ЖИЛ БОЛГОН ЗАРЛАЛАА

“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор 2023-2024 оныг “Нээлттэй Дорноговь” жил болгон зарлалаа. Зорилтод жилийн хүрээнд “Нээлттэй Дорноговь аймаг хөтөлбөр”-ийг аймгийн ИТХ-аар хэлэлцэн батлууллаа.




ЗАРЛАГА




Дорноговь аймагт жилдээ 120 гаруй мянган гадаад, дотоодын жуулчин ирдэг бөгөөд үүний ихэнх нь Хамарын хийд-Хайрхан уул-Шамбалын орныг зорьсон жуулчид, аялагчид байдаг. Аялал жуулчлалыг дэмжих бодлогын хүрээнд Хамарын хийд-Ханбаянзүрх хайрхан чиглэлд хатуу хучилттай авто замыг барьсан.







АЙМГИЙН ОНХС-ГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая төгрөг)





АЙРАГ СУМ

7,400 км² газар нутагтай.



НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /сая төгрөг/



АЙМГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /сая төгрөг/


650.0
Аймаг сумын ЕБС-ийн 1-р байрны их засвар



Дорноговь аймаг нь газрын тос, хайлуур, жонш, зэс молибден, чулуун нүүрс, төмөр зэрэг ашигт малтмалын нөөц ихтэй төдийгүй барилгын түүхий эдийн баялаг нөөцтэй. Энэхүү нөөцөд тулгуурлан өдгөө “Газрын тос боловсруулах үйлдвэр”, “Алтанширээт аж үйлдвэрийн цогцолбор” үйлдвэр баригдаж байгаа төдийгүй Манган боловсруулах үйлдвэр, Ган бөмбөлгийн үйлдвэр, Жонш баяжуулах үйлдвэр, Цагаан суваргын зэс молибдений үйлдвэр, Мон цемент, Мак цементийн үйлдвэр зэрэг боловсруулах, баяжуулах 27 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөлийг бий болгоход Сайншанд, Замын-Үүд, Хатанбулаг сумын хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шилжин суурьшигдчыг хүлээн авах газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд тусгаж, газар олгох бэлтгэл ажлыг хангаад байна. Мөн Сайншанд хотын ерөнхий ерөнхий төлөвлөгөөний дагуу хэтдээ 10 мянган айлын орон сууцыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр барих төлөвлөгөөтэй байна.



СУМЫН ОНХС-ИЙН ЭХ ҮҮСВЭР /САЯ ТӨГРӨГ/



СУМЫН ОНХС-ИЙН ЗАРЦУУЛАЛТ /САЯ ТӨГРӨГ/





АЛТАНШИРЭЭ СУМ



7,200 км² газар нутагтай,

НИЙТ ХҮН АМ - 1,533

БАГИЙН ТОО - 4
ӨРХИЙН ТОО - 960



НИЙТ МАЛЫН ТОО - 196,705



НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /САЯ ТӨГРӨГ/



АЙМГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /САЯ ТӨГРӨГ/




Дорноговь аймгийн нутаг бүхэлдээ говийн бүсэд багтдаг боловч өмнөд хэсэг нь говь, хойд хэсэг нь говь, хээр хосолсон нутаг юм. Дорноговь аймаг нь Монголын зүүн өмнөд хэсгийн талархаг гадаргатай хэсэгт оршдог. Гэхдээ энд Хутаг уул (1436 м), Оцол, Сансар, Их Багадулаан, Аргалант, Хан Баянзүрх хайрхан (1031 м) зэрэг уулууд бий, Нутгийн дундуур зүүн

хойшоо баруун урагшаа их хотгор газар үргэлжилнэ. Аймгийн нутаг далайн түвшнээс дээш дунджаар 952 метрт оршино. Газар нутгийн хамгийн өндөр цэг далайн түвшнээс дээш 1436 метр өргөгдсөн Хутаг уул/Хөвсгөл сум/, хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 700 метр өргөгдсөн Далантүрүүгийн говь/ Улаанбадрах сум/ юм. Дорноговь аймгийн нутагт том гол мөрөн, нуур байхгүй, харин газар доорхи усны их нөөц бий. Халзан уул, Бусийн Чулууны, Толь булгийн зэрэг рашаан устай. Нутгийн ихэнхэд говийн бор хөрс тархсан бөгөөд элс нилээд байдаг.



СУМЫН ОНХС-ИЙН ЭХ ҮҮСВЭР /САЯ ТӨГРӨГ/





СУМЫН ОНХС-ИЙН ЗАРЦУУЛАЛТ /САЯ ТӨГРӨГ/





ДАЛАНЖАРГАЛАН СУМ

4,100 км² газар нутагтай.




НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /САЯ ТӨГРӨГ/



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /САЯ ТӨГРӨГ/




АЙМГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /САЯ ТӨГРӨГ/

Дорноговь аймаг нь өнөөгийн соёлт хүн төрөлхтний мөнхийн бүтээл болох ноён хутагт Данзанравжаагийн шашин, түүх, бичиг, соёлын өв дурсгалыг хадгалж үлдсэн юм. Ноён хутагт 1803 онд Түшээт хан аймгийн Мэргэн вангийн хошууны нутаг Шувуун шанд хэмээх газарт ядуу ард Дулдуйтын хүү болон төрж, хожим нь шашин төрийн зүтгэлтэн, гүн ухаантан, зохиолч, яруу найрагч, найруулагч, зураач, эм баригч, ая зохиогч, соён гэгээрүүлэгч хэмээн олноо алдаршиж, нэгэн биед багтаж ядсан их авьяас билэг, нэгэн хүн дааж ядсан өндөр их нэр хүндийн эзэн болсон юм. Тэрээр иргэний уянгын 500 орчим шүлэг, яруу найраг, 120 гаруй дууны ая дан, 50 орчим сүм хийдийг цогцлоон бүтээж, уран зураг, сийлбэр, жүжгийн зэрэг урлагийн бүхий л хэлбэрийг говь нутагтаа хөгжүүлсэн шашин, түүх, бичиг, соёлын аугаа их өв дурсгалыг үлдээсэн соён гэгээрүүлэгч байлаа. 2023 онд Д.Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн тэгш ой тохионо.



СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (сая.төг)



СУМЫН ОНХС-ГИЙН ЗАРЦУУЛАЛТ (сая.төг)





ДЭЛГЭРЭХ СУМ

4,800 км² газар нутагтай.

НИЙТ ХҮН АМ - 1,918

БАГИЙН ТОО - 4
ӨРХИЙН ТОО - 582



297,678


1,343

22,099

104,806

14,914


154,516



НИЙТ ХӨРӨНГӨ ОРГУУЛАЛТ (сая.төг)




АЙМГИЙН ТӨСӨВИЙН ХӨРӨНГӨ ОРГУУЛАЛТ (сая.төг)




Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт гадаад харилцааны чиглэлээр “Хөрш болон өндөр хөгжилтэй орнууд, тэдгээрийн муж, хотуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэн, олон тулгуурт гадаад харилцааны бодлогыг хэрэгжүүлж, аймгийнхаа эдийн засаг, нийгмийн хөгжилд дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлнэ” хэмээн заасан. Манай аймаг ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, АНУ, БНТУ, БНЭУ, АНЭУ-ын Элчин сайдын яамдууд, Оросын Шинжлэх ухаан, соёлын төв, БНХАУ-аас Замын-Үүд суманд суугаа Ерөнхий Консулын газар, “Жайка” Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, “Койка” Солонгосын олон улсын хамтын ажиллагааны агентлаг, “Near” Зүүн хойд Азийн нутгийн захиргааны холбоо, Азийн хөгжлийн банк гэх мэт бүс нутгийн болоод олон улсын томоохон байгууллагуудтай нийгэм, эдийн засгийн өргөн хүрээнд хамтран ажилладаг.



СУМЫН ОНДС-ГҮЙН ЭХ ҮҮСЭЭР (млн.төг)




СУМЫН ОНДС-ГҮЙН ЗАРЦУУЛАЛТ (млн.төг)





ИХ ХЭТ СУМ

4,200 км² газар нутагтай.



НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)



АЙМГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая.төг)




Дорноговь аймагт Ерөнхий боловсролын 22 сургууль, 41 цэцэрлэг, Политехникийн коллеж, АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургууль зэрэг эрүүл мэнд, боловсролын байгууллагууд

ажилладаг. Соён гэгээрүүлэгч Данзанравжаагийн нэрэмжит “Саранхөхөө” театр, Хүүхдийн ордон, Залуучуудын хөгжлийн төв, Иргэдийн хөгжлийн төв, Усан спорт сургалтын төв, Нийтийн номын сан, 1000 хүний багтаамжтай спорт цогцолбор, Музей сургалт судалгааны төв, Ноён хутагт Данзанравжаагийн музей, DTV телевиз, Бизнес хөтөч 89.1 радио, DSB телевиз, “Өнөөгийн Дорноговь” сонин, “Өнөөдрийн ялалт” сонин, Dornogovipost.mn зэрэг соёл, хэвлэл мэдээллийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна.



СУМЫН ОНОС-ГИЙН ЭХ ҮҮСЭЭР (₮мл.Төг)



СУМЫН ОНОС-ГИЙН ЗАРИУУЛАЛТ (₮мл.Төг)





МАНДАХ СУМ



12,700 км² газар нутагтай,

НИЙТ ХҮН АМ - 1,550

БАГИЙН ТОО - 5
ӨРХИЙН ТОО - 506



НИЙТ МАЛЫН ТОО - 201,726




НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (000.Төг)



АЙМГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (000.Төг)





Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор хүн амынхаа тоог 20 хувиар буюу 14628 мянгаар нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж ажиллана. Орон нутагт иргэдийг татах чиглэлээр:

“Нутаг сэтгэл” нутгийн зөвлөлийн уулзалт,
 Энергийн төв-Говь нутаг”-т тавтай морил уулзалт,
 “Дорнын сайхан говь” соёл, спортын өдөрлөг,
 Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд аймгийн талаар олон нийтэд сурталчлах өдөрлөг зэрэг арга хэмжээг зохион байгуулна.

Хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр:


“Хөрөнгө оруулагчид, баялаг бүтээгчдийн нэгдсэн чуулган”
 Орон нутгийн бизнес эрхлэгчидтэй хөрөнгө оруулагчдыг холбон зуучлах судалгаа, нөлөөллийн ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Хүний нөөцийг татах чиглэлээр:

“Их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгсөж байгаа оюутан залууст чиглэсэн “Нутгаа зорьё”, “Нутгийн хөгжил-Ажлын гараа” зэрэг өдөрлөгийг зохион байгуулна.



СУМЫН ОНОС-ГИЙН ЭХ ҮҮСЭЭР (млн.төг)





СУМЫН ОНОС-ГИЙН ЗАРИЦУУЛАЛТ (млн.төг)





ӨРГӨН СУМ

8,700 км² газар нутагтай.



НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (млн.төг)



АЙМГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (млн.төг)




“Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв”-өөс хийдэг судалгаагаар аймгуудын өрсөлдөх чадварыг Дэд бүтэц, Бизнесийн үр ашиг, Засаглалын үр ашиг, Эдийн засгийн тамир тэнхээ гэсэн 4 үндсэн үзүүлэлтийн хүрээнд дүгнэдэг бөгөөд энэхүү үзүүлэлтээр Дорноговь аймаг 2017 онд 8 дугаар байр, 2018 онд 4 дүгээр байр, 2019 онд 3 дугаар байр, 2020 онд 2 дугаар байр, 2021 онд 1 дүгээр байранд эрэмбэлэгдэж байсан бол 2022 онд дахин 1 дүгээр байранд орж амжилтаа бататгасан.

Дорноговь аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2”, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 6 зорилт 312 арга хэмжээтэйгээр боловсруулан, аймгийн ИТХ-ын 2020 оны 02/06 дугаар тогтоолоор батлуулж, орон нутгийн хөгжлийг хурдасгах, хүн амын ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, байгаль орчны чиглэлээр ногоон байгууламжийг нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байна.



СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (млн.төг)



СУМЫН ОНХС-ГИЙН ЗАРЦУУЛАЛТ (млн.төг)





САЙСАНДУЛААН СУМ

9,500 км² газар нутагтай.


НИЙТ ХҮН АМ - 1,411

БАГИЙН ТОО - 4


ӨРХИЙН ТОО - 475




НИЙТ МАЛЫН ТОО - 213,751




НИЙТ ХЭРЭНГЭ ОРУУЛАЛТ (000.төг)



АЙМГИЙН ТӨСВИЙН ХЭРЭНГЭ ОРУУЛАЛТ (000.төг)



СҮЛЭЙН ОНОС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (омн.төг)



СҮЛЭЙН ОНОС-ГИЙН ЗАРЦУУЛАЛТ (омн.төг)





УЛААНБАДРАХ СУМ



11,400 км² газар нутагтай.

НИЙТ ХҮН АМ - 1,519

БАГИЙН ТОО - 4
ӨРХИЙН ТОО - 536



НИЙТ МАЛЫН ТОО - 198,088



НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (000.0төг)



АЙМГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (000.0төг)




Монгол туургатны олон зууны туршид идээшин дасаж, түүх, соёлоо бүтээж, он цагийг элээж ирсэн говь нутгийн нэгээнхэн хэсэг нь Улаанбадрах сум билээ.

1924 оноос орон нутаг засаг захиргааг шинэчлэн байгуулах тухай Засгийн газрын шийдвэрийн дагуу Мэргэн вангийн хошууны ардын төлөөлөгчдийн хурлаар 4 сум, 12 баг, 59 аравт, 6107 хүн амтай Хутаг уулын хошууг зохион байгуулжээ. Тэр үед Улаанбадрах сумын айл өрхүүд нь Өлзийт баг нэртэйгээр Хутаг уулын хошууны Цээл суманд харьяалагдаж байжээ. Улмаар нэг жилийн дараа шинээр сум байгуулах санаачилга гарган хөдөлмөрчдийн хурлыг 1925 онд хийж, Цээл сумаас тасран Улаанбадрах сум нь Өлзийбадрах нэртэйгээр үүсгэн байгуулагдсан түүхтэй.



СУМЫН ОНХС-ГИЙН ЭД ҮҮСВЭР (омн.төг)




СУМЫН ОНХС-ГИЙН ЗАРЦУУЛАЛТ (омн.төг)





ХАТАНБУЛАГ СУМ

18,700 км² газар нутагтай.



НИЙТ ХЭРЭНГЭ ОРУУЛАЛТ (сая.төг)



АЙМГИЙН ТӨСВИЙН ХЭРЭНГЭ ОРУУЛАЛТ (сая.төг)



Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дахь говийн үзэсгэлэнтэй сайхан газруудын нэг ба сумын төвөөс баруун хойш 20 гаруй км зайтай бөгөөд энэ нутгаас олдсон эрт галавын олон амьтны чулуужсан яс дэлхийн болон Монголын байгалийн түүхийн музейнүүдэд хадгалагдаж байдаг. Байгалийн сонин тогтоцтой археологийн олдвор ихтэй газар бөгөөд 30 сая гаруй жилийн өмнөх

шим ертөнцийн гэрч болсон эртний сүүн тэжээлтэн загас, яст мэлхий, гүрвэл зэрэг сээр нуруутны олдворыг хадгалсан хурдас чулуулгаас тогтсон ширээ хэлбэрийн тэгш өндөрлөг юм. Иймээс эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилгоор 1996 онд УИХ-ын 43 дугаар тогтоолоор 609 км кв талбайг улсын тусгай хамгаалалтад авсан байна.



СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСЭЭР (₮млн, ₮тг)



СУМЫН ОНХС-ГИЙН ЗАРЦУУЛАЛТ (₮млн, ₮тг)





Хөвсгөл сум



8,400 км² газар нутагтай

НИЙТ ХҮН АМ - 1,534

БАГИЙН ТОО - 4
ӨРХИЙН ТОО - 496




НИЙТ МАЛЫН ТОО - 208,918



НИЙТ ХЭРЭНГЭ ОРУУЛАЛТ (млн.төг)




АЙМГИЙН ТӨСВИЙН ХЭРЭНГЭ ОРУУЛАЛТ (млн.төг)



Дорноговь аймгийн Хөвсгөл сум нь аймгийн төв Сайншандаас 160 км-т, Улаанбаатар нийслэлээс 624 км-т байрладаг. 8400 кв/км нутагтай. Хөвсгөл сум нь Түшээт хан аймгийн Мэргэн вангийн хошууны нутаг бөгөөд Ардын хувьсгал мандсаны дараа 1924 онд Хутаг уулын хошууны Цээл сум, Ойдог зангийн сум, 1925 онд Өлзийт, 1929 онд Жавхлант, 1931 онд Гурван Хөвгөл уулын энгэрт төвлөрч Хөвсгөл сум болжээ.



СУМЫН ОНХС-ГИЙН ЭД ҮҮСВЭР (000.Тг)



СУМЫН ОНХС-ГИЙН ЗАРЦУУЛАЛТ (000.Тг/аар)



Тус сумын нутагт Хонгорын, Дэрсэнэ усны хийд, Бор хамарын хүрээ, Бат-өлзийтийн, Буурын, Бумбатын, Цагаан гэрийн хурал буюу 2 хийд 1 хүрээ, 5 хурал, 29 жас байсан байна. 1940-50-иад оны үед Хутагийн таван сум-Хатанбулаг, Агаруут, Айлбаян, Улаанбадрах, Хөвсгөл сумдын бага сургуулиас дэвшин дунд сургуульд суралцах хүүхдүүд энэ суманд төвлөрч сурдаг байсан учраас энэ сургуулийг төгссөн үе үеийн олон арван хүүхэд дээд боловсролтой болох зам мөрөө гарган улс ардын аж ахуйн удирдах ажилтан, багш эрдэмтэн мэргэд олноор төрөн гарсан.






ЭРДЭНЭ СУМ

9,600 км² газар нутагтай.

НИЙТ ХҮН АМ - 2,418

БАГИЙН ТОО - 5
ӨРХИЙН ТОО - 814



НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (000.төг)



АЙМГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (000.төг)




Дорноговь аймгийн Эрдэнэ сум нь анх 1924 оны эхээр Ёст бэйс гэх /хуучин Цогтой гүний хошуу/ хошууг Сүж уулын хошуу болгон байгуулсан боловч Ардын Их хурлын 10-р сарын 24-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор татан буулгаж Сүж сум болгон Их Дулаан Уулын хошуунд харъяалуулжээ. 1940 онд Аюуш даргатай Эрдэнэ сум /Замын долоодод байхдаа/ 80 мянган толгой мал өсгөснөөрөө

“Хөдөлмөрийн гавьяаны одон”-гоор шагнагдаж байсан.

Дорноговь аймгийн Эрдэнэ сум нь 959,6 мянган га нутаг дэвсгэртэй, Засаг захиргааны 5 багтай, 2341 хүн амтай, 752 өрхтэй. Төрийн 5 байгууллага, 13 аж ахуйн нэгж байгууллага, нэг хилийн отряд, төмөр замын 6 байгууллага, 9 зөрлөг, хэсгүүд үйл ажиллагаа явуулж байна.



СУМЫН ОНХС-ГИЙН ЭД ҮҮСВЭР (омн.төг)




СУМЫН ОНХС-ГИЙН ЗАРЦУУЛАЛТ (омн.төгрөг)





САЙНЦАНД СУМ

2,300 км² газар нутагтай.



НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (000.төг)




















УЛСЫН ТӨСӨВНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (000.төг)



АЙМГИЙН ТӨСӨВНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (000.төг)



АЙМГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (онн төгрөг)


 <p>70.0 3-р багт хийгдэх Товь парк" цэцэрлэгт хүрээлэнд гүний худаг, нөөцийн сав</p>	 <p>159.7 3-р багт Алтанговь-1 гудамжны замын урд талаар дугуйн зам барих</p>	 <p>650.0 7-р багт ЕБ-ын 3 дугаар сургуулийн бага сургуулийн авто замыг ургалжлүүлэн 700м авто зам</p>	 <p>581.2 4, 7 дугаар баг төмөр замын гармаас Оргил худалдааны төвийн урлаар дуртал 2.4 км</p>	 <p>750.0 6-р баг, Шинэ зууны гудамжны автозамд нөхөөс хийх, явган хүний зам дугуйн зам шинээр</p>
 <p>141.9 6-р багийн гэр хорооллын гудамжаар цэвэр усны шугам татах</p>	 <p>257.0 7-р баг 509, 509а байрны авто зогсоол байгуулах</p>	 <p>374.2 8 дугаар багт Залуус хорооллын авто зогсоол байгуулах</p>	 <p>255.8 Цагдаагийн газрын өргөтгөлийн барилга барих</p>	 <p>55.0 Жаргалан зуслангийн гадна цохилгаан хангамжийг сайжруулах</p>
 <p>30.0 Жаргалан зуслангийн гүний худаг гаргах</p>	 <p>300.0 Сайншанд сумын дулаан цэвэр усны төв шугам сүлжээний их засвар</p>	 <p>128.0 "Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа" бохир соруулах автомашин</p>	 <p>541.8 Хамарын хийдийн дүрсгалт газрын гэрэлтүүлэг хийх</p>	 <p>50.0 Ханбаянзүрх хайрханы шатны 2 талаар нарны энергийн гэрэл суурьцуулах зам талбайг</p>
 <p>67.0 Хамарын хийдийн Шамбалын орны орчимд нийтийн бие засах газар барих</p>	 <p>798.3 Хамарын хийдийн Шамбалын орныг 108 агуйтай холбоосон автозам, зогсоол</p>	 <p>555.0 Аймгийн ЗДТГ-г тоног төхөөрөмж худалдан авах</p>	 <p>175.0 Сумдад шаардлагатай компьютер, техник хэрэгсэл худалдан авах ажил</p>	 <p>108.7 Асрамжийн газарт тоног төхөөрөмж худалдан авах</p>
 <p>703.6 Ахмадын сувиллын газарт тоног төхөөрөмж худалдан авах</p>	 <p>235.7 Зарим сумдын газар зүйн нэрийн тодруулалт хийх</p>	 <p>100.0 Зарим сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийг паспортжуулах</p>	 <p>600.0 Хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөө гүйцэтгэх зардал</p>	 <p>45.0 Зөвсөгт хүчний 336-р ангийн гадна фасад дэвээр засвар</p>



АЙМГИЙН ТҮСВЭЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (онн төгрөг)



Сумын ОНХС-гийн ЭД ҮҮСВЭР (оан.төг)




Сумын ОНХС-гийн ЗАРЦУУЛАЛТ (оан.төг)



СУМЫН ОНХС-ГИЙН ЭХ ҮҮСВЭР (000.төг)



СУМЫН ОНХС-ГИЙН ЗАРЦУУЛАЛТ (000.төг)



Сайншанд сум нь Дорноговь аймгийн төвийн сум бөгөөд 1931 оны 05 дугаар сарын 26-нд аймгийн анхдугаар их хурлыг 23 сумаас сонгогдсон 40 төлөөлөгчтэйгээр Сайн ус гэдэг газар хуралдуулж, аймаг төвлөрөх газрыг Далай Сайншанд хэмээн тогтсон байна. Үүнээс өмнө аймгийн төвийг Олдох, Олон шанд, Шинэ ус, Хадан хошуу, Сайн ус хэмээх газруудад төвлөрүүлж байсан юм. БНМАУ-ын Ардын Их хурлын Тэргүүлэгчдийн 1961 оны 136



дугаар зарлигаар Сайншанд хот гэсэн статустай болсон. Өдгөө Сайншанд сум нь Улаанбаатар–Замын-Үүд босоо тэнхэлгийн засмал зам болон Олон улсын төмөр замын зангилаан дээр байрладаг, төвийн эрчим хүчний системд холбогдсон, дэд бүтэц хөгжсөн хот бөгөөд 23 гаруй мянган хүн амтай. Сайншанд сум нь хүний хөгжлийг дээдэлсэн, амьдрах таатай орчинг бүрдүүлсэн, байгаль орчинд ээлтэй, аж үйлдвэрлэл, аялал жуулчлалаар тэргүүлэгч, эдийн засгийн өндөр чадавхтай, хөгжлийн тулгуур хот болох эрхэм зорилготой.





ЗАМЫН-ҮҮД СУМ

400 км² газар нутагтай.



НИЙТ ДЭРЭНГЭ ОРУУЛАЛТ (0млн.Төг)



УЛСЫН ТӨСӨВНИЙН ДЭРЭНГЭ ОРУУЛАЛТ (0млн.Төг)



АЙМГИЙН ТӨСӨВНИЙН ДЭРЭНГЭ ОРУУЛАЛТ (0млн.Төг)



НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (000.төг)




УЛСЫН ТӨСӨВНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (000.төг)




АЙМГИЙН ТӨСӨВНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (000.төг)



СУМЫН ОНДС-ГИЙН ЭХ ҮҮСЭЭР (₮мл.Төг)



СУМЫН ОНДС-ГИЙН ЗАРЦУУЛАЛТ (₮мл.Төг)



Хүн амын оршин суух, хөгжих таатай нөхцөлийг хангасан, экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, ухаалаг, тогтвортой засаглалыг бэхжүүлсэн, эдийн засаг, нийгмийн бие даасан Монгол Улсын хөгжлийн тулгуур аймаг болно” гэж алсын хараагаа тодорхойлсон. Мөн “Иргэдийн амар тайван аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж, ажилгүйдэл, ядуурлын түвшинг бууруулан, байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг цогцлоон, төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй, хариуцлагатай, байдлыг төгөлдөршүүлж, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд өссөн, үндэсний тэргүүлэгч аймаг болно” гэж эрхэм зорилгодоо тусгасан.

Дорноговь аймаг нь байнгын ажиллагаатай хоёр хилийн боомтоо түшиглэн хил орчмын аялал жуулчлал, газар нутгийн хэмжээ байршилдаа тулгуурлан хөдөө аж ахуй болон уул уурхай, аж үйлдвэрийн парк хот болон хөгжүүлэхээр олон ажлууд хийгдэж байна.



НЭР, НЭРШЛИЙН ТАЙЛБАР

ТӨСВИЙН ОРЛОГО:

Хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого

ТӨСВИЙН ЗАРЛАГА:

Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгө

ТЭНЦЭЛ:

Тухайн төсвийн жилийн төсвийн нийт орлого, зарлагын зөрүү

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах хөрөнгө

ТӨСВИЙН АШИГ:

Төсвийн зарлагаас давсан орлого

ТӨСВИЙН АЛДАГДАЛ:

Төсвийн орлогоос давсан зарлага

ТӨЛӨӨЛӨН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТӨРИЙН ЧИГ ҮҮРЭГ:

Нэгжийн удирдлагад төрөөс шилжүүлсний дагуу түүний нэрийн өмнөөс хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн шинжтэй асуудлууд

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

Төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн зардлыг хөрөнгө оруулалт гэнэ

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САН:

Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоср дахин хуваарилалт хийх хөрөнгө

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО:

Тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь, хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэр

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА:

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлагын нийлбэр

ТӨСВИЙН ТОДОТГОЛ:

Тухайн жилийн төсвийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулахыг төсвийн тодотгол гэнэ



АЙМАГ, СУМЫН ЧИГ ҮҮРЭГ:

ЗЗНДНТУТХ-ийн 21-22-р зүйл		Аймаг	Сум
НУТГИЙН УДИРДЛАГА	Аймгийн дунд хугацааны хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт	✓	
	Сумын хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт		✓
	Орон нутгийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт	✓	✓
	Орон нутгийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт	✓	✓
	Хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох	✓	✓
	ОНХС-гийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт	✓	✓
	Аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр	✓	
	Аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөл		✓
ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧИН	Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, хэрэгжилтэд тавих хяналт	✓	
	Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт		✓
	Аймгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн менежмент	✓	
	Аймгийн аялал жуулчлалын бодлого, менежмент	✓	
	Аялал жуулчлалын үйл ажиллагааны зохицуулалт		✓
ХОТ, НИЙТИЙН АЖ АХУЙ, ДЭЭД БҮТЭЦ	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага		✓
	Гудамж, талбайн нэр, хаягжилтын нийтлэг зохицуулалт	✓	
	Суурин газрын гэрэлтүүлэг, арчлалт		✓
	Харилцаа, холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт,	✓	
	Сум хоорондын нийтийн тээврийн зохицуулалт	✓	
	Сумын хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт		✓
	Орон нутгийн зам, гүүр тэмдэг, тэмдэглэгээ, арчлалт, хамгаалалт		✓
	Суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоолын зохицуулалт		✓
	Нийтийн зэмшлийн зам талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт		✓
	Орон нутгийн цэвэрлэх байгууламжийн арчлалт		✓
	Гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу, арчлалт		✓
	Аюултай болон үйлдвэрлэлийн хог хаягдлын менежмент	✓	
	Хог хаягдлын цэгийн байршил, энгийн хог хаягдлын менежмент		✓
Оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт		✓	
ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ	Худалдаа, үйлчилгээний нийтлэг зохицуулалт	✓	
	Худалдаа, үйлчилгээний зохион байгуулалт, хяналт		✓
НИЙГЭМ, СОЁЛЫН САЛБАР	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, нэгдсэн эмнэлэг, аймгийн музей, театр, номын сан, соёлын ордон, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ	✓	
	Сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ		✓
	Хөшөө дурсгалын нийтлэг зохицуулалт	✓	
	Хөшөө дурсгалын байршил, хамгаалалт		✓



ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

- ▶▶ ДНБ Дотоодын нийт бүтээгдэхүүн
- ▶▶ ЕБС Ерөнхий боловсролын сургууль
- ▶▶ ЗАН Заах аргын нэгдэл
- ▶▶ ЗДТГ Засаг даргын Тамгын газар
- ▶▶ ЗЗНДНТУТХ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- ▶▶ ИТХ Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
- ▶▶ НДШ Нийгмийн даатгалын шимтгэл
- ▶▶ ОНӨААТҮГ Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
- ▶▶ ОНХС Орон нутгийн хөгжлийн сан
- ▶▶ СӨББ Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
- ▶▶ ТБОНӨХБАҮХАТ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- ▶▶ УИХ Улсын Их Хурал
- ▶▶ ЭМТ Эрүүл мэндийн төв



